



**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025
ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БИЧМЭЛ ТАЙЛАН**

**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

- 1. Нэгжийн чиг үүрэг, бодлогын баримт бичгийн талаар**
 - 1.1 Удирдлага зохион байгуулалт**
 - 1.2 Хүний нөөцийн талаар**
 - 1.3 Иргэний улсын бүртгэл**
 - 1.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэл**
 - 1.5 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл**
 - 1.6 Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаа**
 - 1.7 Архивын үйл ажиллагаа**
- 2. Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилт**
 - 2.1 Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар, тушаалын хэрэгжилт**
- 3. Санхүүгийн үйл ажиллагаа**
 - 3.1 Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ**
- 4. Мэдээллийн технологийн талаар**
 - 4.1 Ил тод байдал**
 - 4.2 Шилэн данс**
- 5. Бусад**
 - 5.1 Бусад байгууллагатай хамтран ажилласан тухай, Идэвхи санаачлага шинэлэг ажил**

НЭГ: НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААР

1.1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2025 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтын дагуу Монгол улсын үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмуудыг хэрэгжүүлэн иргэний бүртгэлийн чиглэлээр, 6142 иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2298 иргэн, хуулийн этгээдийн чиглэлээр 833 иргэн нийт 9273 иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэн ажиллалаа.

1.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2025 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, ахлах мэргэжилтэн-1, хуулийн этгээд улсын бүртгэгч 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 4, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 3, архивч 2, Ерөнхий нягтлан бодогч 1, бичиг хэргийн эрхлэгч нярав 1, мэдээллийн технологийн ажилтан 1, Гэрээт албан хаагч 5, сумдын улсын бүртгэгч 24 нийт 46 ажилтан, албан хаагчтайгаар улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.



2025 онд Цэцэн-Уул суманд сул орон тоотой ажиллаж байна.

1.3 ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ


Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 6142 иргэнд үзүүлсэн байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6142 бүртгэлийн 11292 нотлох баримтыг цахимжуулж, хянан мэдээллийн санд баталгаажуулсан байна. Тоон гарын үсгийг 2025 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 29472 иргэдэд олгосон.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж хяналтын улсын байцаагчийн 1 дүгнэлт гаргуулж ИУБ-11, ИУБ-15, ИУБ-16 маягтуудыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан. Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 327 иргэний мэдээллийг нэгдсэн дүгнэлтүүдээр засварлан ажиллаж байна.


2025 оны Иргэний улсын бүртгэлийг графикаар харуулбал



Үрчлэлт,эцэг тогтоолт,овог нэр өөрчлөлт



Шилжилт хөдөлгөөн



Олгосон лавлагааны тоо

Иргэнд киоск машинаар 2660, улсын бүртгэгч нараас 1055 лавлагаа албан хэрэгцээнд 810, албан тоотоор 233 лавлагааг өгч ажилласан байна. 2025 оны 06 дугаар сарын байдлаар нийт 7 албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллаж байна.

ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР

2024 онд олгосон гадаад паспортын үйлчилгээг харьцуулсан үзүүлэлт

Д/д	Он	Гадаад паспорт шинэ	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
1	2023 он	2293	0	213
2	2024 он	2839	0	801
3	2025 он 05 сар	1192	0	483

1.4 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Тайлант хугацаанд нийт 833 бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу хийсэн. Асгат, Тосонцэнгэл, Баянтэс, Сонгино, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Их-Уул, Тэс, Нөмрөг, Тэлмэн, Сантмаргаз суманд 385 бүртгэл буюу нийт бүртгэлийн 46,2 хувийг эзэлж байна.

Үүнд:

Д/д	Хуулийн этгээдийн бүртгэлийн төрөл	2023 он	2024 он	2025 он
1	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт	162	300	269
2	Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд	87	139	199
3	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	65	47	52
4	Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/	9	16	21
5	Нөхөрлөл	4	1	4
6	Хоршоо	5	71	116
7	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	2	0	0
8	Сан	0	2	0
9	Төрийн байгууллага, албан газар	0	1	6
10	Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт	126	129	140
11	Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон	95	103	85
12	Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл	6	0	3
	Нийт	561	809	833

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу аймагт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 201 олгож, хуулийн этгээдийн 20 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 199 хуулийн этгээдийн, 140 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн, лавлагааны эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг журмын дагуу архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

1.5. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭНД

Тайлант хугацаанд нийт 2298 мэдүүлэг хүлээн авч эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 2298 бүртгэлийг хийсэн. Тосонцэнгэл, Баянтэс, Сонгино, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Их-Уул, Тэс, Нөмрөг, Тэлмэн, Сантмаргаз суманд 795 бүртгэл буюу нийт бүртгэлийн 34,7 хувийг эзэлж байна.


Нийт бүртгэлийн тоог өмнөх онуудтай харьцуулвал:




Нийт бүртгэлийг төрлөөр нь өмнөх онуудтай харьцуулвал:




Шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл




Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл




Өмчлөх эрх шилжих бүртгэл



Бусад бүртгэл




Барьцааны бүртгэл



Тайлант хугацаанд нийт 758 гэрчилгээ бичиж олгосноос 421 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн, 337 газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ бичигдсэн байна.

Бүртгэж олгосон гэрчилгээ:



Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын дагуу байгууллагад үйлчилгээний хураамжаас 37.710.928 сая төгрөг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамжаас 3.005.206 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны албан татвараас 116.332.517 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаж байна.

Нийт мэдүүлгийг цахим мэдээллийн сан болох Electronic Property Registration System (ePRS)-т 2298 бүртгэлийг шивж оруулсан бөгөөд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 242 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 90 хувийн хэрэг шинээр нээж, 9 хувийн хэрэг хааж, 1966 мэдүүлгийн бүртгэлийн үйлчилгээний баяжилтыг бүртгэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 100 лавлагаа мөн хууль хяналтын байгууллагаас ирсэн 20 тоотын 35 иргэний лавлагаа мэдээллийг холбогдох хууль журмын дагуу гаргасан. Монголын ипотекийн корпорацийн барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай Онлайн мэдүүлэг 4, ХААН, Төрийн банкны нийт 37 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн. Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн 85 хувийн хэрэгт засвар өөрчлөлт хийсэн. Хилийн цэс өөрчлөгдсөн 7 хувийн хэргийн эрхийн улсын бүртгэлийн дугаарыг өөрчилөн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу эд хөрөнгийн бүртгэлийн тоо мэдээг 5 удаа, Улсын бүртгэлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9854 дугаар “Мэдээний маягт хүргүүлэх тухай”-ын хүрээнд тайланг заасан маягт загварын дагуу 5 удаа, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 5/2787, 2025 оны 04 дүгээр сарын 09-ны 5/4982 “Хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх тухай”-ын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2 удаа, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 5/6824 “Чиглэл, үүрэг даалгавар хүргүүлэх тухай”-ын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 1 удаа, 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 5/6168 “Мэдээлэл ирүүлэх тухай”-н хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох улсын бүртгэгч нарын судалгааг 1 удаа, Үнэт цаасны мэдээг 5 удаа гарган холбогдох газарт нь хүргүүлэн ажиллаж байна.

Хоёр. Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хүрээнд

Энэ хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн тушаал, чиглэл, зөвлөмж, санал авах тухай тайлан ирүүлэх тухай, хугацаатай үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь Улсын бүртгэгч нарт танилцуулан хүргүүлэн дотоод сүлжээ болох 100 дотор байршуулан сумдын Улсын бүртгэгч нарт онлайнаар 10 удаа заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

1.6. ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах хяналтын улсын байцаагчийн 5 дүгнэлт гарган, 92 бүртгэлд хяналт тавьж, 1 зөрчил илрүүлэн 1 зөрчлийг шалгалтын явцад шийдвэрлэсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 59 бүртгэлд хяналт тавьж, 14 зөрчил илрүүлэн 7 зөрчлийг шалгалтын явцад арилган шийдвэрлэсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах

хяналтын улсын байцаагчийн 18 дүгнэлт гарган, 98 бүртгэлд хяналт тавьж, 21 зөрчлийг илрүүлэн 2 зөрчлийг шалгалтын явцад шийдвэрлэсэн. Мөн тайлант хугацаанд 2 бүртгэл хүчингүй болгон ажиллалаа.

Эхний хагас жилийн байдлаар 287 бүртгэлд цахимаар хяналт тавин, зөрчилтэй 3 бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган ажиллалаа.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 5, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 18, зөрчлийн талаарх 86 гомдол мэдээллийг нийт 109 өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан зөрчилд улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр заасны дагуу 86 иргэнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1.720.000 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулан ажилласан байна.

Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн бүртгэлийг 21 удаа, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 5 удаа аймгийн Прокурорын газарт хянуулан ажиллаж, аймгийн Прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2020-2025 оны 05-р сар хүртэлх хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 1 удаа шалгуулан ажиллаж байна.

Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу хуулийн этгээд улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хяналт шалгалт хийж дүнг илтгэх хуудсаар Хэлтсийн даргад танилцуулан УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн илэрсэн 36 зөрчлийг шийдвэрлэн ажиллалаа.

Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тавьсан бүртгэлийн тоо өмнөх оноос 47.3 хувиар буурч, илрүүлсэн зөрчлийн тоо 61,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.7.АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтын архивын үйл ажиллагааг сайжруулах, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, архивын баримт, хадгаламжийн нэгжийг эмх цэгцтэй байлгах, иргэд, аж ахуй нэгж, байгуулагад үзүүлэх архивын үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 242, газрын 90 хувийн хэрэг шинээр нээгдсэн бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөн 2268 хувийн хэрэгт баяжилтыг хийсэн байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 199 шинээр аж ахуй нэгж нээгдсэн Улсын бүртгэгчээс хүлээн авч архивт байршуулан ажиллалаа.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 3539, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 17351, Иргэний улсын бүртгэлийн архивт 73900 хувийн хэрэг, 920 бүртгэлийн дэвтэр тус тус хадгалагдаж байна.



Иргэний улсын бүртгэлийн архивын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр шинээр бүртгэл хийгдсэн ИУБ11-587 ширхэг, ИУБ12-12 ширхэг, ИУБ13-20 ширхэг, ИУБ14-22 ширхэг, ИУБ15-108 ширхэг, ИУБ16-12 ширхэг, ИУБ18-194 ширхэг, ИУБ31-1804 ширхэг нийт 2759 ширхэг ИУБ маягтуудыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулан баяжилт хийн ажиллаж байна.

Шинээр 16 насанд хүрч иргэний үнэмлэх авсан 732 иргэний ХААТР-11 маягтыг хүүхдийн сангаас түүвэрлэн авч ИУБ-31 маягтын хамт хувийн хэргийн санд байршуулан баяжилт хийж ажиллаж байна.

194 иргэний ИУБ-18 маягтыг тухайн хувийн хэргийн хамт түүвэрлэн нас баралтын санд байршуулсан.

Шилжилт хөдөлгөөний дагуу гадна аймаг нийслэл рүү шилжин явсан 77 иргэний хувийн хэргийг архивын сангаас түүвэрлэн жагсаалт үйлдэн холбогдох аймаг, нийслэлд хүргүүлсэн.

Гадна аймаг, нийслэлээс шилжин ирсэн 42 иргэний хувийн хэргийг архивын санд байршуулан баяжилт хийн ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр бүртгэл хийгдсэн 24 сумдын хадгаламжийн нэгж 427 хуудас, бүртгэлийн бүрдүүлсэн баримт 37 хадгаламжийн нэгж 4722 хуудас, түр хадгалах 86 хадгаламжийн нэгж 10806 хуудас, гадаад паспорт олголтын 57 хадгаламжийн нэгж 13931 хуудас бүхий хадгаламжийн нэгжүүдийг улсын бүртгэгч нараас хүлээн авч бүртгэл хөтлөн архивын санд тус бүрээр нь байршуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9/16182 албан бичгийн дагуу 2025 оны I-р улиралд багтаан баримт устгах ажлын зохион байгуулахтай холбоотой 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр БНШК-ын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар хурлаар хэлэлцэж хадгалах хугацаа дууссан 408 хадгаламжийн нэгж 66184 хуудас бүхий, 4130 ширхэг ИУБ-21 дүгээр маягтыг устгах ажлыг БНШК-ын гишүүдийн хамт устгалд оруулав.

ХОЁР: ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ

2.1 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВАР, ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 4 удаагийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтүүдийг гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын Улсын бүртгэгч томилож, чөлөөлсөн 1 тушаал, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай 1, Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2, Урамшуулал олгох тухай 1, Иргэн, ХЭЭХЭУБГ-талаар 8-н чиглэл, тайлан ирүүлэх тухай, хугацаатай үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь Улсын бүртгэгч нарт бүрэн танилцуулан хүргүүлэн сумдын бүртгэгч нарт онлайнаар 23 удаа заавар зөвлөгөө өгч, эдгээр чиглэл зөвлөмжийг бүртгэл хөтлөхдөө мөрдлөгө болгон ажилласан байна.


ГУРАВ: САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 САНХҮҮ, ҮНЭТ ЦААСНЫ ТООЦОО, ТАЙЛАН МЭДЭЭ

Төсвийн зарцуулалт: Улсын төсвөөс 961.6 сая төгрөгийн санхүүжилт авч Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 901.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 31.4 сая, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой урамшуулал тусламж дэмжлэгт 16.0 сая, бусад бараа үйлчилгээний зардалд 12.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайланг сар бүрийн 2-ны дотор 5 удаа, улирлын тайлангуудыг холбогдох тодруулгын хамт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Төрийн аудитаар хянуулж “Зөрчилгүй” дүгнэлтээр үнэлэгдсэн болно.

Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого: 2025 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогоос 65.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 75.8 сая төгрөгийг Улсын төсвийн 170000075756 тоот дансаар дамжуулан төвлөрүүлж 17.0 хувиар давуулан биелүүлж ажиллалаа.



Бараа материал, үндсэн хөрөнгө:

Иргэний улсын бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хөрөнгийн санхүүжилтээр 2 удаагийн татан авалт хийж нөөцийг бүрэн ханган ажиллаж байна. Хэлтэс шинэ байранд орсонтой холбоотой цэвэрлэгээ, засвар үйлчилгээний зардал нэмэгдсэн боловч батлагдсан төсөвтөө багтаан зарцуулалт хийж ямар нэгэн өр, авлагагүй ажилласан.

Тайлант хугацаанд сумдын Улсын бүртгэгчид болон албан хаагчидад олгосон үнэт цаас, хаатр маягт, бичиг хэргийн материалуудыг зохих журмын дагуу шаардах хуудас бичүүлж, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтөлж, өгсөн үнэт цаасны хатуу дугаарыг онлайн програмд хуваарилан ажиллаж байна.

ДӨРӨВ :МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, Монгол улсын Засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

4.1 МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба хагас жилийн байдлаар цаг үе, үйл явдлын талаарх мэдээ 18, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 23-г байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.Zavkhan.burtgel.gov.mn хаягт 33 мэдээ мэдээлэл мөн [Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д](#) 82 мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан

үед цаг алдалгүй 23 удаа засварлаж хэвийн ажиллагаанд ажиллуулж байна. Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал болон сургалт 18 удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник тоног, төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сумдын улсын бүртгэгч нарт цахим видео хурал болон сургалтыг 23 удаа хийн холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийн ажиллаж байна.

4.2 ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг” Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлж буй. Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, ажлын хүрээнд <https://frontoffice-dev.shilen.gov.mn/index> 5 чиглэлийн 87 мэдээллийг байршуулан ажиллаж 2025 оны нэгдүгээр улиралд 70.85% үнэлэгдэж 2-р улирлын тайланг 6 дугаар сарын 30-ны дотор илгээхээр ажиллаж байна.

Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Улсын бүртгэлийн хууль тогтоомж тушаал шийдвэр төсөв санхүү, статистик тоо мэдээ, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайт шилэн данстай холбон мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба цахим хуудас болон [facebook](https://www.facebook.com/shilen.gov.mn) хуудсанд хагас жилийн байдлаар 82 мэдээ мэдээлэл тавигдсан байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахимд байршуулсан.

4.3 ШИЛЭН ДАНС

Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Улсын бүртгэлийн хууль тогтоомж тушаал шийдвэр төсөв санхүү, статистик тоо мэдээ, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайт шилэн данстай холбон мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг сар бүрийн 8-ны өдрийн дотор 29 үзүүлэлтээр 68 мэдээллийг бүрэн байршуулж, улирлын тайланг хугацаанд нь илгээн ажилласан.

ТАВ: БУСАД

5.1 БУСАД БАЙГУУЛЛАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТУХАЙ, ИДЭВХИ САНААЧЛАГА ШИНЭЛЭГ АЖИЛ

Улиастай сумын төрийн байгууллага, аж ахуйн нэгж нийт ард иргэдийн дунд “Цасны баяр-2025” арга хэмжээг зохион байгуулсан арга хэмжээнд хамт олноороо оролцов.



Завхан аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан спортын олон төрөлд уралдаан тэмцээнд амжилттай оролцон эмэгтэй гар бөмбөгийн төрөлд МӨНГӨН МЕДАЛЬ хүртсэн амжилттай оролцсон



Улирал бүр зохион байгуулдаг Төрийн албаны нөөц бүрдүүлэх шалгалтыг Завхан аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран төрийн албан хаагчийн шалгалтад бүртгүүлсэн иргэдийг нягтлан шалгаж, хурууны хээг уншуулан программд бүртгэн оруулж хамтран ажиллалаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН-ЗАВХАН



Зарлан мэдээллийн дуут дохиогоор гамшигаас сэргийлэх дасгал сургуулилтад “Нийгмийн хамгааллын бүлэг”-ийн “Иргэний бүртгэл мэдээллийн бүлэг” 10 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдлаа.



“Хамгийн чухал нь эрүүл мэнд” зорилтот хөтөлбөр нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар хэрэгжиж буй бөгөөд яамны харьяа агентлаг, байгууллагын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын албан /алба/ хаагчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг өргөн хүрээтэй эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН-ЗАВХАН



Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран засан хүмүүжигч нарт Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч Тоон гарын үсэг олгож ажиллалаа.



Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулж байгаа "НЭГ НОМ-НЭГ СЭТГЭЛ" номын хандивын аянд нэгдэж Албан хаагч нар ном бэлэглэж хамтран ажиллалаа.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН-ЗАВХАН



Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын тамгын газраас жил бүр зохион байгуулладаг Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд Байгууллагын гадна орчин болон хуваарьт газрыг цэвэрлэн оролцлоо.



"ЗӨӨВРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН" Отгон сумын засаг даргын тамгын газартай хамтран НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ өдөрлөг зохион байгууллаа.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН-ЗАВХАН



Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэд сурталчлах, энхийг сахиулагчдын алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор аймгийн Төв талбайд уг арга хэмжээг зохион байгуулагдлаа.



“ГЭРЛЭЛТИЙН БАТЛАХ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ”-ийг Завхан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран 4 дахь удаагаа хамтран зохион байгууллаа.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус хэлтсийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Завхан аймгийн прокурорын газартай хамтран “АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ”-ээс урьдчилан

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН-ЗАВХАН

сэргийлэх нь сэдвээр хэлтсийн ажилтан, албан хаагчдад Завхан аймгийн прокурорын газрын Ахлах прокурор Б.Сансарбаяр мэдээлэл, сургалтыг зохион байгуулж хэлтсийн ажилтан, албан хаагчид бүрэн хамрагдлаа.



"Гэр бүлийн боловсрол олгох цуврал 8 модуль"-ийн "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчдад зохион байгууллаа.



Завхан аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Дохионы хэлний дунд хугацааны 16 цагийн багц сургалт"-д Хэлтсийн 9 албан хаагч хамрагдаж чадамжийн гэрчилгээ гардан авлаа.



ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
---oOo---